



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/139/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит"
ХХК-ийн захирал С.Должинсүрэн
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6.	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3.	Аудитын тайлан.....	13
3.1.	Ерөнхий зүйл.....	13
3.2.	Байгууллагын зорилго, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3.	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4.	Материаллаг байдал.....	14
3.5.	Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7.	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8.	Аудитын гол асуудал.....	17
3.9.	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10.	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11.	Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4.	Аудитын илрүүлэлт.....	18
4.1.	Зөвлөмж.....	18
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН ДАРГА
Г.АМАРТҮВШИН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/327
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	97,203,344.98	105,788,185.18
33	АВЛАГА	28,340,345.00	22,187,120.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	208,000.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	27,686,345.00	22,187,120.45
335	Бусад авлага	446,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	446,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	68,862,999.98	83,601,064.73
351	Түүхий эд материал	7,318,678.00	3,174,039.00
35110	Тусгай зориулалттай материал	7,318,678.00	3,174,039.00
354	Хангамжийн материал	61,544,321.98	80,427,025.73
35410	Бичиг хэргийн материал	48,441,336.00	62,679,228.75
35420	Аж ахуйн материал	6,041,860.00	8,927,377.00
35440	Түлш, шатах тослох материал	2,516,254.98	2,931,548.98
35470	Бусад хангамжийн материал	4,544,871.00	5,888,871.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	892,039,112.55	1,424,643,195.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	892,039,112.55	1,424,643,195.93
392	Биет хөрөнгө	762,970,101.35	1,325,526,039.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	274,077,529.00	274,077,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(59,065,815.12)	(88,598,722.68)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,827,358.88	86,827,358.88
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,783,014.95)	(77,719,194.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,365,119,264.35	2,106,136,131.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(865,926,163.95)	(999,950,511.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,515,538.67	53,515,538.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,905,646.33)	(33,532,646.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,745,440.00	3,745,440.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(680,989.20)	(1,021,483.80)
39217	Ном	2,046,600.00	2,046,600.00
393	Биет бус хөрөнгө	129,069,011.20	99,117,156.87
39301	Програм хангамж	82,363,084.00	84,189,084.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(40,845,066.12)	(57,032,920.41)
39303	Бусад биет бус хөрөнгө	92,747,660.00	92,747,660.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(5,196,666.68)	(20,786,666.72)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	989,242,457.53	1,530,431,381.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	654,000.00	177,775,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	654,000.00	177,775,000.00
413	Өглөг	654,000.00	177,775,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	654,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	177,775,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	988,588,457.53	1,352,656,381.11
51	Засгийн газрын хувь оролцоо	988,588,457.53	1,352,656,381.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	923,780,524.52	923,780,524.52
51101	Өмч: - төрийн	923,780,524.52	923,780,524.52
512	Хуримтлагдсан үр дүн	(213,015,035.99)	151,052,887.59
51210	Өмнөх үеийн үр дүн	(408,120,044.33)	(213,015,035.99)
51220	Тайлант үеийн үр дүн	195,105,008.34	364,067,923.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	277,822,969.00	277,822,969.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	989,242,457.53	1,530,431,381.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,156,795,529.23	2,635,393,663.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	217,614,429.23	332,386,463.57
120	Нийтлэг татварын бус орлого	217,614,429.23	332,386,463.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	217,614,429.23	332,386,463.57
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,105,510.35	191,060,432.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,636,560.00	10,346,252.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,872,358.88	130,979,778.75
122	Тусламжийн орлого	-	-
122001	Хандив тусламж /дотоод/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,939,181,100.00	2,303,007,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,919,381,100.00	2,251,007,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,632,054,900.00	1,751,077,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	287,326,200.00	500,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,800,000.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,800,000.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,000,000.00	47,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,961,690,520.89	2,271,325,739.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,961,690,520.89	2,271,325,739.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,925,873,217.12	2,082,047,669.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,773,742.05	1,296,436,368.38
210101	Үндсэн цалин	1,364,773,742.05	990,638,593.20
210102	Нэмэгдэл цалин		292,084,062.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		13,713,713.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,487,104.80	171,359,278.68
210201	Тэтгэврийн даатгал	131,391,849.51	120,173,524.62
210202	Тэтгэмжийн даатгал	10,899,549.01	13,341,783.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,524,759.55	10,414,707.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,988,904.44	2,393,987.67
210205	Эрүүл мэндийн даатгал	20,682,042.29	25,035,274.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,421,398.75	25,610,253.83
210301	Гэрэл, цахилгаан	18,807,364.00	13,828,525.75
210302	Түлш, халаалт	10,751,138.51	6,500,800.71
210303	Цэвэр, бохир ус	5,862,896.24	5,280,927.37
2104	Хангамж, бараа материалын зардал	50,139,196.00	42,635,611.18
210401	Бичиг хэрэг	2,677,520.00	4,898,176.00
210402	Тээвэр, шатахуун	5,538,345.02	6,323,906.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,934,396.98	28,426,535.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	907,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,548,934.00	2,079,694.00
2105	Нормативт зардал	-	93,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		93,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,112,600.00	689,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	797,000.00	639,900.00
210604	Урсгал засвар	1,315,600.00	50,000.00
2107	Томилолт, зочны зардал	403,500.00	-
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	403,500.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,729,475.50	153,341,182.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,610,962.00	69,019,330.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	570,210.00	463,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,304.00	313,874.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,771.69	1,726,820.00
210807	Газрын төлбөр	280,300.00	95,970.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	80,889,927.81	77,722,188.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	148,806,200.02	391,881,474.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,612,320.00	115,730,779.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	146,193,880.02	276,150,695.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,817,303.77	189,278,070.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,950,000.00	73,315,378.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,950,000.00	750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	41,615,378.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00	30,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,867,303.77	115,962,692.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,867,303.77	115,962,692.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	195,105,008.34	364,067,923.58
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	195,105,008.34	364,067,923.58

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(408,120,044.33)	793,483,449.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			195,105,008.34	195,105,008.34
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(213,015,035.99)	988,588,457.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	(213,015,035.99)	988,588,457.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			364,067,923.58	364,067,923.58
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	923,780,524.52	277,822,969.00	151,052,887.59	1,352,656,381.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,177,447,125.35</u>	<u>2,509,750,439.22</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,316,025.35	206,743,239.22
120	Нийтлэг татварын бус орлого	190,316,025.35	206,743,239.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	190,316,025.35	206,743,239.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	190,316,025.35	206,743,239.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,987,131,100.00	2,303,007,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,919,381,100.00	2,251,007,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,632,054,900.00	1,751,007,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	287,326,200.00	500,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,750,000.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,750,000.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,000,000.00	47,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,842,170,925.35</u>	<u>2,009,750,439.22</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,842,170,925.35	2,009,750,439.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,806,353,621.58	1,820,472,368.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,773,742.05	1,296,436,368.38
210101	Үндсэн цалин	1,231,846,401.39	996,723,817.12
210102	Нэмэгдэл	129,137,542.66	286,019,928.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,789,798.00	13,692,623.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,487,104.80	171,196,608.53
210201	Тэтгэврийн даатгал	131,391,849.51	119,656,539.50
210202	Тэтгэмжийн даатгал	10,899,549.01	13,430,203.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,524,759.55	10,485,442.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,988,904.44	2,412,305.65
210205	Эрүүл мэндийн даатгал	20,682,042.29	25,212,116.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,007,998.75	25,610,253.83
210301	Гэрэл, цахилгаан	18,393,964.00	13,828,525.75
210302	Түлш, халаалт	10,112,732.45	6,500,800.71
210303	Цэвэр, бохир ус	6,501,302.30	5,280,927.37
2104	Хангамж, бараа материалын зардал	56,527,474.29	43,094,918.18
210401	Бичиг хэрэг	7,995,448.31	5,493,729.00
210402	Тээвэр, шатахуун	7,777,100.00	6,216,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,934,396.98	28,426,535.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	907,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,380,529.00	2,050,754.00
2105	Нормативт зардал	1,012,000.00	93,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,012,000.00	93,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,492,500.00	1,235,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	759,900.00	639,900.00
210604	Урсгал засвар	3,732,600.00	595,800.00
2107	Томилолт, зочны зардал	778,500.00	778,500.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	778,500.00	778,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	162,299,431.69	146,622,108.46

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,610,962.00	69,019,330.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	570,210.00	463,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	321,304.00	313,874.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,806,771.69	1,726,820.00
210807	Газрын төлбөр	280,300.00	95,970.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,709,884.00	71,003,114.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,974,870.00	135,404,311.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,974,870.00	135,404,311.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,817,303.77	189,278,070.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,950,000.00	73,315,378.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,950,000.00	750,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	41,615,378.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00	30,950,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,867,303.77	115,962,692.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,867,303.77	115,962,692.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>335,276,200.00</u>	<u>500,000,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	335,276,200.00	500,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	335,276,200.00	500,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	335,276,200.00	500,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	287,326,200.00	500,000,000.00
223001	Бусад хөрөнгө	47,950,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(335,276,200.00)</u>	<u>500,000,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,977,782,300.00	1,841,787,746.38	135,994,553.62	93.12
УРСГАЛ ЗАРДАЛ	1,977,782,300.00	1,841,787,746.38	135,994,553.62	93.12
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,893,590,400.00	1,799,422,368.38	94,168,031.62	95.03
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,364,837,300.00	1,296,436,368.38	68,400,931.62	94.99
Үндсэн цалин	1,001,664,800.00	996,723,817.12	4,940,982.88	99.51
Нэмэгдэл	347,936,300.00	286,019,928.26	61,916,371.74	82.20
Унаа хоолны хөнгөлөлт	15,236,200.00	13,692,623.00	1,543,577.00	89.87
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,253,000.00	171,196,608.53	13,056,391.47	92.91
Тэтгэврийн даатгал	129,659,500.00	119,656,539.50	10,002,960.50	92.29
Тэтгэмжийн даатгал	13,648,400.00	13,430,203.53	218,196.47	98.40
ҮОМШӨ ний даатгал	10,918,700.00	10,485,442.86	433,257.14	96.03
Ажилгүйдлийн даатгал	2,729,700.00	2,412,305.65	317,394.35	88.37
Эрүүл мэндийн даатгал	27,296,700.00	25,212,116.99	2,084,583.01	92.36
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,054,100.00	25,610,253.83	6,443,846.17	79.90
Гэрэл, цахилгаан	12,311,800.00	13,828,525.75	(1,516,725.75)	112.32
Түлш, халаалт	10,134,000.00	6,500,800.71	3,633,199.29	64.15
Цэвэр, бохир ус	9,608,300.00	5,280,927.37	4,327,372.63	54.96
Хангамж, бараа материалын зардал	40,634,600.00	40,594,918.18	39,681.82	99.90
Бичиг хэрэг	7,423,800.00	5,493,729.00	1,930,071.00	74.00
Тээвэр, шатахуун	3,716,600.00	3,716,600.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,363,100.00	28,426,535.18	(2,063,435.18)	107.83
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	907,300.00	907,300.00	-	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,223,800.00	2,050,754.00	173,046.00	92.22
Нормативт зардал	106,100.00	93,600.00	12,500.00	88.22
Нормын хувцас, зөөлөн эдлэл	106,100.00	93,600.00	12,500.00	88.22
Эд хогшил, урсгал засварын зардал	1,304,100.00	1,235,700.00	68,400.00	94.76
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	639,900.00	639,900.00	-	100.00
Урсгал засвар	664,200.00	595,800.00	68,400.00	89.70
Томилолт, зочны зардал	3,074,500.00	778,500.00	2,296,000.00	25.32
Äîïïà àëàáí òìëëïëò	778,500.00	778,500.00	-	100.00
Çì-èì òëëëëà- òçëýýí àààò	2,296,000.00	-	2,296,000.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,660,800.00	128,072,108.46	2,588,691.54	98.02
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,796,800.00	64,019,330.46	1,777,469.54	97.30
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	463,000.00	463,000.00	-	100.00

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	313,874.00	36,126.00	89.68
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,727,500.00	1,726,820.00	680.00	99.96
Газрын төлбөр	280,300.00	95,970.00	184,330.00	34.24
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	58,043,200.00	57,453,114.00	590,086.00	98.98
Бараа үйлчилгээний бусад зардал	136,665,900.00	135,404,311.00	1,261,589.00	99.08
Бараа үйлчилгээний бусад зардал	136,665,900.00	135,404,311.00	1,261,589.00	99.08
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,191,900.00	42,365,378.00	41,826,522.00	50.32
Бусад урсгал шилжүүлэг	84,191,900.00	42,365,378.00	41,826,522.00	50.32
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	797,600.00	750,000.00	47,600.00	94.03
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,394,300.00	41,615,378.00	41,778,922.00	49.90
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000,000.00	500,000,000.00	-	100.00
Дотоод эх үүсвэрээр	500,000,000.00	500,000,000.00	-	100.00
Тоног төхөөрөмж	500,000,000.00	500,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,477,782,300.00	2,341,787,746.38	135,994,553.62	94.51
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,292,782,300.00	2,135,044,507.16	157,737,792.84	93.12
Улсын төсвөөс санхүүжих	1,792,782,300.00	1,635,044,507.16	157,737,792.84	91.20
Хөрөнгийн санхүүжилт	500,000,000.0	500,000,000.0	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	185,000,000.00	206,743,239.22	(21,743,239.22)	111.75
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	180,000,000.00	206,743,239.22	(21,743,239.22)	110.18
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-	-	168.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	108	108	-	100.0
Удирдах ажилтан	2	2	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	99	99	-	100.0
Үйлчлэх ажилтан	7	7	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	108	108	-	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	14	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	94	94	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			<i>/төгрөгөөр/</i>
	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	52,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	52,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,500,000.00
2104	Хангамж бараа материалын зардал	-	
210402	Тээвэр шатахуун	-	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	-	18,550,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		5,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэн бэлтгэх	-	13,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,950,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	30,950,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	
2200	Дотоод эх үүсвэр	-	
223001	Бусад хөрөнгө	-	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	52,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	
131103	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	47,000,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу МОНЦАМЭ агентлагийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд мөнгөн хөрөнгийн зарцуулалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, үндсэн хөрөнгийн шийдвэрлэлт, төсвийн төлөвлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудитор Н.Бат-Оюун нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

МОНЦАМЭ агентлаг нь “Монгол Улсыг дэлхий нийтэд сурталчлах болон дэлхий дахины мэдээллийг монголчуудад хүргэх хамгийн шуурхай, үр дүнтэй, баталгаатай эх сурвалж” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсын төр, засгийн удирдлага ба төв байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, өргөн олон нийтийг улс орны дотоод амьдралын шуурхай мэдээллээр хангах,
- Гадаад ертөнц, олон улсын хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллээр хангах,
- Монгол Улсын гадаад, дотоод бодлого, дотоодын үйл явдал, улс орны хөгжил дэвшлийг гадаадад мэдээлэх, сурталчлан таниулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2021 оны 400 дугаар тогтоол “Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МОНЦАМЭ агентлагийн даргын 2021 оны А/10 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, тайлант онд 10 ажлыг хийхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,961,690.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 39,233.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 31,387.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 541,188.9 мянган төгрөгөөр буюу 54.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	28,340.4	22,187.1	(6,153.3)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зарал)		-	
Бараа материал	68,863.0	83,601.1	14,738.1
Үндсэн хөрөнгө	892,039.1	1,424,643.2	532,604.1
Нийт хөрөнгө	989,242.5	1,530,431.4	541,188.9
Өр төлбөр	654.0	177,775.0	177,121.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	988,588.5	1,352,656.4	364,067.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	989,242.5	1,530,431.4	541,188.9

Авлага дансны үлдэгдэл 22,187.1 мянган төгрөг болж 6,153.3 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагын тооцоог барагдуулснаас шалтгаалжээ.

Тус дансны үлдэгдэлд Монгол шуудан ХХК-иас авах төлбөртэй үйлчилгээний 10,192.8 мянган төгрөг, Түгээмэл шуудан компаниас авах 2,716.7 мянган төгрөг, Мэдээлэл холбооны операторуудын ассоциациас 3,960.0 мянган төгрөг, бусад байгууллага, хувь хүнээс авах авлагын 5,317.6 мянган төгрөгийг бүртгэж тайлагнасан бөгөөд тооцоог бүрэн нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 83,601.1 мянган төгрөг болж 14,738.1 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хэвлэл захиалгын тоо буурч, улмаар бичиг хэргийн материалын зарцуулалт багассан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,424,643.2 мянган төгрөг болж 532,604.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 677,775.0 мянган төгрөгийн хэвлэх тоног төхөөрөмж худалдан авч, ТӨБЗГ-ын А-1/997 дугаар шийдвэрээр 129,153.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,826.0 мянган төгрөгийн програм хангамж хүлээн авч суурилуулан, ТӨБЗГ-ын 2021 оны 129 дүгээр шийдвэрээр 3 нэр төрлийн 65,991.9 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан нь шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 177,121.0 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны ХХОАТ-ын суутгалын зөрүү 654.0 мянган төгрөгийг барагдуулж, тайлант онд Ном хур ХХК-иас 677,775.0 төгрөгийн өртөгтэй Хэйделберг РМ-52-5 хэвлэх машин худалдан авч төсөвлөгдсөн 500,000.0 мянган төгрөгийн шилжүүлж, 177,775.0 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,352,656.4 мянган төгрөг болж 364,067.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

МОНЦАМЭ агентлагийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 478,598.2 мянган төгрөгөөр буюу 22.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс санхүүжих хөрөнгийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 309,635.2 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн элэгдэл, бараа үйлчилгээний зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн төслийг 3,170,700.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,137,958.5 мянган төгрөгөөр бууруулж 2,032,742.1 мянган төгрөгөөр баталсан байна.

2021 оны төсвийн тодотголоор нийт 1,977,782.3 мянган төгрөг (үүнд:- бараа үйлчилгээний бусад зардлыг 130,683.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,353.4 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7,170.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 26.5 мянган төгрөгөөр, томилолт,

зочны зардлыг 574.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 173,125.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 199.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж)-өөр баталсан байна.

Энэ нь “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх дотоод гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,977,782.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,792,782.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 180,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 5,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,635,044.5 мянган төгрөгийн санхүүжилт, 500,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт тус тус авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 206,743.2 мянган төгрөг, нийт 2,341,787.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,841,787.7 мянган төгрөгийг зарцуулж 115,962.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,841,787.7 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 68,400.9 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 13,056.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 6,443.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 2,296.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,588.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,291.6 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 41,778.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь бараа, ажил үйлчилгээний зардал 94,168.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээ арга хэмжээ 2,588.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг арга хэмжээ 41,826.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 47,000.0 мянган төгрөг, нийт 52,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 2,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 5,000.0 мянган төгрөг, улсын маягт хэвлэн бэлтгэх зардалд 13,550.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 30,950.0 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардалд 47,950.0 мянган төгрөг нийт 52,000.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 400 дугаар тогтоолоор МОНЦАМЭ агентлагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн шинэчлэл хийж “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Аколоус програмыг суурилуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 8 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

МОНЦАМЭ агентлагийн 2021 онд нийт 3,888,173.6 мянган төгрөгийн 84 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулж, хуулийн хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар өгсөн 5 зөвлөмжөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэхээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 75.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-						
Албан шаардлага	1		1				
Зөвлөмж	4	2,315.0	3	2,315.0	1	-	75.0
Нийт дүн	4	2,315.0					

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 24,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх талаар 4 зөвлөмж өгсөн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Арга хэмжээний зардлын 19,000.0 мянган төгрөгийн төсөвт зардлын зарцуулалтын тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан мөнгөн урьдчилгааны тайлан НХМаягт ТМ-2 маягтаар гаргаж тайлагнаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2. Анхан шатны бүртгэлийн хөтлөлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд нэр бүхий 25 аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан худалдан авалт, ажил үйлчилгээний гэрээний хэрэгжилт, үр дүнг нарийвчлан тооцож гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт, ажил үйлчилгээний гэрээний хэрэгжилт, бүртгэл тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тус агентлагийн үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжгүй 4 нэр төрлийн 418 ширхэг буюу нийт 307,678.0 мянган төгрөгийн актлах хөрөнгө байна гэж тооллогын комиссын дүгнэлт гарсан боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гараагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн актлах шаардлагатай хөрөнгийн асуудлыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн ТӨБЗГ-т тавьж холбогдох журмын дагуу шийдвэрлэх.

4. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тус агентлагийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаанаас үзэхэд 2019-2021 онуудад жил бүр үндсэн үйл ажиллагааны орлогоос 180,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөгийг санхүүжихээр төсөвлөсөн боловч туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл гараагүй ба үндсэн үйл ажиллагааны орлогыг 5.7- 18.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;" , 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МОНЦАМЭ агентлагийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4	МОНЦАМЭ агентлаг	АХГ-2022/139/НА-СТА-ТШЗ	Тус агентлагийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн судалгаанаас үзэхэд 2019-2021 онуудад жил бүр үндсэн үйл ажиллагааны орлогоос 180,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөгийг санхүүжихээр төсөвлөсөн боловч туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл гараагүй ба үндсэн үйл ажиллагааны орлогыг 5.7- 18.8 хувиар давуулан биелүүлсэн байна.	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн төлөвлөлтийг бодитой төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.	1	5,000.0							1	5,000.0
Нийт дүн					4	24,000.0							4	24,000.0

